

Манмин Мэдээ

Номер 26 2012 оны Есдүгээр сарын 16

“Номыг нээвэл ирээдүй харагдана.”

2012 оны Сөүлийн Олон улсын номын үзэсгэлэн худалдаанд “Урим Ном” хэвлэлийн газар нь, Доктор И Жей руг пасторын Олон орны хэлнээ орчуулагдсан 475 орчим номнуудыг дэлгэн тавьж оролцлоо.



Сөүлийн 2012 Олон улсын номын үзэсгэлэн худалдаа нь “Номыг нээвэл ирээдүй харагдана.” Гэсэн сэдвийн дор Сөүл хотын Самсунг донг КОЕКС үзэсгэлэн яармагийн танхимд Зургадугаар сарын 20-ноос 24-ны хооронд зохион байгуулагдав. Тус үзэсгэлэн худалдаанд нийт 20-иод орны 580 орчим хэвлэл нийтлэлийн байгууллагууд оролцсон ба ялангуяа Саудын Араб улс болон ойр орчмын улсын хэвлэлийн байгууллага оролцож Арабын соёл урлаг болон хэвлэл нийтлэлийг олны хүртээл болгов. Үүний дунд бүх дэлхийн хүн төрөлхтөнийг авралын зам руу хөтлөж, олон орны хэл дээр амийн үг сургаалийг хэвлэн гаргадаг манай төв сүмийн ‘Урим ном’ хэвлэлийн байгууллага нь хүрэлцэн ирэгсэдийн сонирхол анхаарлыг ихэд татаж байлаа. ‘Урим ном’ хэвлэлийн байгууллагын сурталчилгааны хэсэгт гадаад болон дотоодын маш олон хэвлэлийн байгууллагууд болон үзэж сонирхогчид, хүрэлцэн ирсэн ба тэр дундаас Номхон далайн Азийн орнуудын хэвлэл мэдээллийн холбооны ерөнхийлөгч Сония Сантьяго зэрэг албаны бусад эрхэм зочдоор дүүрэн байлаа.

Олон орны хэл дээрх хэвлэлийн салбарт манлайлж буй ‘Урим ном’ хэвлэлийн газар

Еврей хэлээр ‘Урим’ гэдэг нь гэрэл гэгээ

гэсэн үг ба бүх дэлхий даяар жинхэнэ гэрлийг гэрэлтүүлэх гэрэл гэсэн утга бүхий ‘Урим ном’ хэвлэлийн газар нь анх байгуулагдсанаас хойш Христийн ном хэвлэлийг Солонгосдоо болон дэлхий даяарх олон хэлэн дээр тараан тунхаглах үйлсэд ихээхэн хувь нэмэр оруулсаар байгаа билээ. Ингэж Христийн сургаал номлолыг хэвлэл мэдээлэлээр дамжуулан сайн мэдээ тараах нь хэсэгхэн зуур ивээл авах бус хэзээ ч гэсэн дахин уншиж, энэрэл ивээлийг авах боломжтой гэдэг талаасаа маш чухал ач холбогдол бүхий сайн мэдээ тараах хэрэгсэл юм.

1987 онд Доктор И Жей руг пасторын гэрчлэл болох “Ухлийн өмнө мөнхийн амьдралыг амссан нь” хэмээх ном хэвлэж эхэлсэнээс хойш “Загалмайн Үг”, “Итгэлийн Хэмжээ”, “Тэнгэрийн орон I ба II”, “Там”, “Сэрэгтүн Израйль”, “Их Эзэний мөр”, “Долоон Сүм” болон “Хайр бол хуулийн биелэл” зэрэг номуудыг хэвлэн гаргасан ‘Урим ном’ хэвлэлийн газар нь дээрх үзэсгэлэн худалдаанд Солонгос хэл дээрх 79 төрлийн номууд болон 40-өөд орны хэлээр орчуулагдан гарсан 194 төрлийн номууд түүнчлэн, 32 орны хэл дээрх 201 төрлийн цахим ном орос хэл дээрхи аудио хэлбэрийн номыг дэлгэн танилцуулсан юм.

33 орны хэл дээр орчуулагдсан

“Загалмайн Үг” ном

‘Урим ном’ хэвлэлийн газрын сурталчилгааны байр нь гэрэл болох Бурханыг мэдрүүлэхүйц цагаан өнгө болон угийн гэрлийг илэрхийлэх мэт төрөл бүрийн үзэсгэлэнтэй гэрлээр чимэглэгдсэн бөгөөд дэлхийн хэвлэл мэдээлэл болон орчуулгын хандлагыг нийгэд харагдахуйцаар зассан байв.

Сурталчилгааны байрны гол хэсэгт ‘Урим ном’ хэвлэлийн газрын хэвлэл мэдээллийн ерөнхий байдлыг танилцуулсан самбар байрлах ба одоогийн байдлаар 74 орны хэл дээр орчуулагдаж байгаа номнуудын талаарх танилцуулга ч байв. 33 орны хэл дээр орчуулагдсан дэлхий даяарх Манмины итгэгчдийн итгэлийн суурь болох, Христэд итгэгч нарын унших ёстой номуудыг нэг болох “Загалмайн Үг” номыг бахархалтайгаар танилцуулан Бурхандаа алдар өргөн барьж байв. Түүнчлэн ялангуяа тэдгээр номуудын дотор 15 хэлнээ орчуулагдсан “Там” хэмээх ном нь оролцогчдын анхаарлыг ихэд татаж байсан ба сурталчилгааны байрны нэг буланд цахим номуудыг дэлгэн тавьж, үзэж сонирхох боломж олгосноор оролцогчдын сэтгэлд ихэд таалагдсан юм.

Энэтхэгийн Үндэсний номын хяналтын албаны ажилтан Кумар Викрам нь Доктор И Жей руг пасторын сургаал номлолууд

ингэж олон орны хэл дээр орчуулагдан тавигдсан болохыг үзээд ихэд сайшаан, ‘Урим ном’ хэвлэлийн газрыг 2013 онд болох Энэтхэгийн Нью-Дэли олон улсын номын үзэсгэлэн худалдаанд оролцохыг хүссэн юм.

Чех улсаас суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайн Ярослав Олса болон Ханкук их сургуулийн олон улсын харилцааны салбарын Чех болон Словак хэлний профессор Ивана Боздечова нар “Солонгост Чех хэл дээр орчуулагдан гарсан нь гайхалтай явдал” хэмээн ихэд гайхаж байлаа.

Үүнээс гадна сурталчилгааны байранд АНУ, Франц, Индонези, Тайван ба Энэтхэгийн хэвлэл мэдээллийн компаниуд ч ‘Урим ном’ хэвлэлийн газартай хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлцгээж байлаа.

Энэ удаагийн үзэсгэлэн худалдаанд оролцсоноороо ‘Урим ном’ хэвлэлийн газар Солонгосдоо болон дэлхийн даяарх хэвлэлийн үйл ажиллагааг өргөжүүлэх төдийгүй, хүүхэд, сурагч оюутнуудад зориулсан, шинэ итгэгч болон итгэгч бус хүмүүст ч гэсэн зориулсан номуудыг гаргах, олон орны хэл дээрх ном ба цахим ном, аудио ном, зэрэг төрөл бүрийн хэрэгслээр дамжуулан дэлхий даяар сайн мэдээ тараах шинэ хандлагыг бий болгож байна.

«Загалмайн Үг» цувралаас -(24)

Мөнхийн Амьдрал (1)

Хүний Хүүгийн мах ба цусыг идэж ууснаар мөнх амьдрал (1)

“Есүс тэдэнд-Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Хэрэв та нар Хүний Хүүгийн махыг идэхгүй, цусыг нь уухгүй л бол та нарын дотор амь байхгүй. Миний махыг идэж, цусыг уусан хүн мөнх амьтай бөгөөд Би түүнийг эцсийн өдөрт амилуулна. Учир нь Миний мах бол жинхэнэ хоол, Миний цус бол жинхэнэ ундаа мөн” (Иохан 6:53-55).

Есүсийг Аврагч Эзэнээр хүлээн авч өөрийн гэм нүглээ гэмшвэл Бурхан Ариун Сүнсний өгснөөр дахин төрж, мөнх амийг авах болдог. Тэгэхдээ Эзэнийг хүлээн зөвшөөрөөд дахин төрсөн ч гэсэн төгс мөнх амийг авна гэсэн үг биш бөгөөд сүнслэг хоолыг идэж, ууснаар л Эзэнийг дуурайсан төгс итгэлийн хэмжээнд хүрэх ёстой юм.

Ингэж итгэлээр өсгөх ‘Сүнслэг хоол тэжээл’ гэдэг нь сүнс зүгийн утгаар ‘Хүний Хүүгийн мах ба цус’-г зүйрлэн хэлж байгаа бөгөөд ‘Хүний Хүүгийн мах ба цус’-г идэж ууснаар л бид мөнхийн амьдралыг хүлээн авах билээ (Иохан 6:53-55).

1. Хүний Хүүгийн махыг идэх гэдэг үгийн утга учир

‘Хүний Хүүгийн мах’ гэдэг нь Есүсийн бие махбодь ба сүнслэг утгаар бол библид тэмдэглэгдсэнээр ‘Бурханы Үг’ гэсэн утгатай. Иохан 1:14-д, “Үг нь махан бие болж бидний дунд оршин, бид Түүний алдрыг харцгаасан. Энэ нь Эцэгийн цорын ганц Хүүгийн алдар бөгөөд нигүүлсэл ба үнэнээр дүүрэн байсан юм.” хэмээн дурдсанчлан Бурханы Үг нь ‘махан бие’-ийг өмсөж энэ газар дээр ирсэн Эрхэм бол Есүс болохыг нарийн тодорхой дурдсан байдаг.

Мөн Иохан 6:51-д “Би бол тэнгэрээс бууж ирсэн амьд талх байна. Хэрэв хэн нэгэн энэ талхнаас идвэл, тэр мөнхөд амьдарна. Ертөнцийн амийн төлөө Миний өгөх талх бол Миний махан бие юм гэж айлдлаа” хэмээн айлдсан шиг Есүс Өөрийгөө тэнгэрээс буун ирсэн амьд талх хэмээсэн байдаг.

Бурханы Үг өөрөөр хэлбэл амийн талх болсон Хүний Хүүгийн махыг яаж идэх талаарх тайлбар нь Бяцхан Хурганы зүйрлэлтэй холбоотой юм. Иохан номын 1-р бүлэгт үзвэл баптисм хүртээгч Иохан Есүсийг, “Ертөнцийн нүглийг үүрэгч Бурханы Хургыг харатун!” хэмээн тэмдэглэсэн байдаг (Иохан 1:29).

Энгийн ойлголтоор хонь нь даруу зөөлөн ааштай ба зөвхөн хоньчиныхоо дууг л танин дуулгавартайгаар дагадаг ба хүнд ашиг тусаа өгдөг амьтан юм. Үүний адил, Есүс нь Бурхан Аавынхаа хүсэлд дуулгавартай даган дөлгөөнхөн хонь мэт хүн төрөлхтөний гэмийг золиослох тахил болж өгсөнөөрөө хүнд зөвхөн сайн сайхныг л бэлэглэсэн билээ. Ялангуяа нэг нас хүрч буй өө сэвгүй хурга бусдаасаа даруухан өхөөрдөм байдаг шиг энэ нь сүнслэг утгаар ямар ч өө сэвгүй, буруутгах зүйлгүй бидний Аврагч Есүсийг зүйрлэсэн байдаг билээ.

Египетээс гарсан нь номын 12-р бүлэгт “Египетийн бүх нутагт ууган хүүгийн гамшиг буух үед Бурхан Израйлийн ард түмэнд энэ гай гамшиг буухгүй нь тулд өө сэвгүй нэг настай эр хургыг бариад цусыг нь авч, гэрийнхээ хаалганы баруун зүүн хатавчинд ба тотгонд цуснаас нь нялаад, тэгээд гэртээ хурганыхаа махыг идэх ёстой” хэмээсэн байдаг. Тэгэхдээ Бурханаас Израйльчуудад тэр хурган махыг яаж идэх ёстойг хүртэл зааж өгсөн байдаг ба (Египетээс гарсан нь 12:8-10) энэ нь бидний амь амьдралтай холбоотой сүнслэг сургамжыг агуулсан байдаг.

“Тэд галд шарсан махыг нь исгээгүй талх ба гашуун ногоотой хамт тэр шөнөдөө идэх ёстой. Түүний аль ч хэсгийг нь түүхийгээр,



Доктор И Жей руг Тэргүүн Пастор

эсвэл бүхлээр нь усанд чанаж идэж болохгүй. Харин түүний толгой, гуяыг гэдэс дотортой нь галд шаран ид. Та нар түүний аль ч хэсгийг өглөө болтол үлдээж болохгүй. Өглөө болоход үлдсэнийг нь галд шатаа” (Египетээс гарсан нь 12:8-10).

2. Хурганы махыг идэх арга

1) Түүхийгээр эсвэл бүхлээр нь усанд чанаж идэж болохгүй, харин галд шаран ид.

Энд дурьдаж буй ‘гал’ нь Ариун Сүнсний галыг хэлж байгаа бөгөөд Ариун Сүнсний бялхал дотор Бурханы Үгийг ухаарч ойлгон, өөрийн болгон гэсэн үг юм талх. Ариун Сүнсний галыг асааж, Ариун Сүнсээр бялханы тулд чин сэтгэлийн гал халуун залбирал хийх ёстой юм.

2 Петр 1:20-21-д, “Судрын нэг ч эш үзүүлэгч эш үзүүлэгчийн өөрийнх нь тайлбараар ирээгүйг юуны түрүүнд мэдэгтүн. Учир нь нэг ч эш үзүүлэгч хэзээ ч хүний хүслээр гарсангүй, харин Ариун Сүнсээр хөдөлгөгдсөн хүмүүс Бурханаас айлджээ” хэмээсэн байдаг.

2 Петр 3:16-д, “Тэрчлэн түүний бүх захидалд эдгээрийн талаар бичсэн юм. Захидлуудад нь ойлгоход хэцүү зарим зүйл байдаг бөгөөд харанхуй мунхаг, туйлбаргүй хүмүүс Судрын бусад зүйлсийг ч гуйвуулдаг шигээ тэдгээрийг мушгин гуйвуулж өөрсдийгөө сүйрүүлдэг.” хэмээн айлдсан байдаг ба Ариун Сүнсний бялхал, удирдамжгүйгээр албаар юмуу өөрийн дураар Бурханы Үгийг тайлбарлана гэдэг нь хурганы махыг ‘түүхий’ болон ‘усанд бүхлээр нь чанаж идэх’ тэй адил билээ.

Тэгвэл Бурханы Үгийг ‘түүхийгээр нь идэх’ гэдэг нь юу гэсэн үг вэ? Бурханы Үгэнд агуулагдсан сүнслэг утгыг ойлгохгүй, бичигдсэн тэр чигээр нь буюу үг үсгээр нь хөрвүүлэн тайлбарлахыг хэлж байгаа билээ. Махыг түүхийгээр идэх нь хүний биед сайн шингэж боловсрогдохгүй бөгөөд элдэв гэдэсний өвчин, гүйлгэх зэргээр хүний биед хортой байдаг шиг Бурханы Үгийг ч гэсэн ‘түүхийгээр нь идвэл’ эмх замбараагүй, буруу ойлголтонд хүрдэгийг харж болно.

Жишээлбэл, Матай 6:6-д, “Харин чи залбирахдаа дотоод өрөөндөө орж хаалгаа хаагаад, нууцаар оршигч Эцэгтээ залбир. Нууцаар харагч Эцэг чинь чамд буцааж төлнө” гэсэн байдаг. Хэрэв үүнийг бичигдсэн тэр чигээр нь үг үсгээр нь хөрвүүлбэл энэ

нь ямар нэгэн залбиралын тусгай дотоод өрөө барин түүндээ залбирал үйлдэж байх хэмээн ойлгож болох юм. Гэвч, библийн аль ч хэсэгт үзсэн итгэлийн дээд өвөг дээдсүүд, эш үзүүлэгч нар ингэж залбиралын тусгай дотоод өрөөнд залбирч байсан тэмдэглэлийг олж харахгүй бөгөөд Есүс ч гэсэн дотоод өрөөнд бус ууланд гаран залбирч байсан тухай шинэ гэрээнд тодорхой тэмдэглэгдсэн байдаг.

Эндээс ‘дотоод өрөө’ гэдэг нь сүнслэг утгаар хүний зүрх сэтгэлийг хэлж байгаа бөгөөд ‘дотоод өрөөндөө ороод залбир’ гэсэн нь дотоод өрөөнд ороод хаалгаа хаахад гаднах орчноос тусгаарлагддаг шиг бид залбирал хийхдээ хүнд харуулахын төлөө хоёр нүүртэй байдал гаргалгүй, дэлхий зовнил, ба мөн нойрмоглох, зүүрмэглэх бус чин сэтгэлээсээ Бурхантай холбогдох залбирал хийх ёстойг ухааруулж өгдөг үг юм.

Дараа нь ‘усанд чанаж идэж болохгүй’ гэсэн нь ямар учиртай юм бэ? Энэ нь Бурханд Үгэнд дэлхийн ямар нэгэн онол үзэл, гэх мэт зүйлийг нэмж, өөрчилөх амталж болохгүй гэсэн үг юм. Зарим хүмүүс Бурханы Үгийг заан тунхаглахдаа улс төр, нийгмийн үзэл бодол, зэрэг төрөл бүрийн онол, үзэл санаа, олны чиг хандлагыг болон хэн нэгний эрх ашиг, тусын тулд гэсэн далд явуулга мэт зүйл, “нэгэн мэргэн хүн хэлэхдээ тэгж хэлсэн, тэр суут ухаантан ингэж хэлсэн” гэх мэт дэлхийн мэдлэг болон онолыг дэмжих сурталчилж буй мэт сургаал заадаг хүмүүс байдаг. Хэдий тийм ч гэсэн, хүний бодол санаа мэдлэг нь хязгаарлагдмал бөгөөд хичнээн агуу суут ухаантан, шилдэг онол ухагдахуун байлаа ч гэсэн Бурханы төгс төгөлдөртэй харьцуулахын ч аргагүй гэдэг нь туйлын үнэн билээ. 1 Коринт номын 1:25-нд, “Яагаад гэвэл Бурханы мунхаглал нь хүмүүсээс илүү ухаалаг, Бурханы мөхөс байдал нь хүмүүсээс илүү хүчирхэг юм” хэмээн бичигдсэн байдаг.

Бурханы Үг нь энэ дэлхийн ямар ч мэдлэгээс агуу бөгөөд Бурханы Үг л цор ганц үнэн ба мөнхийн өөрчилөгдөшгүй билээ. Үүнийг үргэлж санан ямар нэг онол, үзэл санаа, өөрийн санаа бодлоо хуваалцахын оронд Ариун Сүнсний бялхал дотор тайлсан Ариун Библийн үг сургаалийг тэр чигээр нь заах хэрэгтэй билээ. Тийм ч учраас Бурханы амьд оршин буй талаар, явал Бурхантай уулзах талаар, итгэгчид рүү хандсан Бурханы хүсэл юу болохыг болон ямар итгэлийн амьдралаар амьдрах, хэрхэн авралд хүрэх талаар сайн ухааруулж өгөх хэрэгтэй билээ. Тиймд энэ нь ийм утгатай тул хурганы махыг ‘усанд чанаж идэж болохгүй’ гэж айлдсан билээ.

2) Толгой ба гуяыг гэдэс дотортой нь бүхлээр нь галд шаран идэх ёстой

Энэ нь библийн Эхлэл номын эхнээс эхлэн Илчлэлт номын төгсгөл хүртэл, өөрөөр хэлбэл библийн 66 номд тэмдэглэгдсэн Бурханы Үг сургаалиудыг өөрийн болгож авна гэсэн үг юм. Библийг уншихдаа зарим хүмүүс Левит ном шиг ойлгоход хэцүү, хэсгийг нь орхиж унших юм уу библид нарийн тодорхой тэмдэглэгдсэн тэмдэг гайхамшигуудад ч гэсэн итгэдэггүй хүмүүс ч байдаг билээ.

Иймэрхүү хүмүүсийн бодол санаанд таарахгүй зүйлүүдийг алгасвал үлдсэн хэсэг нь үнэн ч биш, итгэл болох зүйл ч биш бөгөөд

зөвхөн төлөвшил ухамсар ба ёс зүйн талаарх зүйл л үлдэх юм. Мөн түүнчлэн тэр зүйлийн дотор сахиж хэрэгжүүлэхэд хэцүү зүйлүүдийг нь зүрх сэтгэлээрээ анхаарал хандуулдаггүйн улмаас хичнээн Бурханы Үгийг уншсан ч гэсэн мөнх амийг авах боломжгүй билээ.

Бурханы Үг нь өөрийн санаанд нийцсэн, таалагдсан хэсгийг л авах бус бүхий л үг сургаалиудад төгс итгэж, өөрийн болгох ёстой юм. Тийм ч учраас хургыг идэхдээ толгой болон гэдэс дотортой нь бүхлээр нь идэх ёстой хэмээн тушаасан билээ.

3) Өглөө хүртэл үлдээлгүй идэж, үлдсэн зүйл байвал бүгдийг нь устгах хэрэгтэй

Израйльчуудад тэр хургыг үүр цайхаас өмнө бүгдийг нь идэж чадахгүй бол үлдсэнийг нь галд шатаа гэж айлдсан билээ. Энэ нь сүнслэг утгаар ‘шөнө’ гэдэг нь муу ёрын сүнс сатан дэлхийг захирч байх хугацааг хэлж байгаа билээ. Хүн төрөлхтөний эцсийн үе ойрхон болоход энэ дэлхий гэм нүгэл аажмаар нэмэгдсээр цаг хугацаа өнгөрөх тусам улам харанхуй аймшигт гэм нүгэл жигшүүрт зүйлсээр дүүрэн харанхуйлах юм. Тэгж байгаад цаг нь болоход Эзэн энэ дэлхийд дахин бууж ирэхэд харанхуй зайлж, гэрэл гийсэн өглөө мэт болох юм.

Энэ үед Эзэнтэй агаар мандалд уулзан, хурим найр амралт зэрэг библи дээр тэмдэглэгдсэн бүх үгүүд биелэгдэж мөн итгэгч хүн тус бүрийн хэр зэрэг ариун байдлыг олж шагнал хураасан нь илэрхий болох юм. Өөрийн зөв гэсэн бодол, шунал, биеэ тоох зэрэг нь ямар гэнэн зүйл байсныг, дэлхийн зүйлсийг хайрлах сэтгэл нь хичнээн хоосон болохыг үнэхээр цаг ирэх юм.

Гэсэн хэдий ч аль хэдийн илэрхий болох учир үүнийг засах боломжгүй олохгүй бөгөөд нэгэнт хоцорч оройтсон учраас ямар ч зүйл хийж чадахгүй болох болно. Тиймээс өглөө болохоос өмнө өөрөөр хэлбэл Эзэн энэ газар дээр дахин залран ирэхээс өмнө хичээнгүйлэн библийн 66 номыг уншиж судлан, хэрэгжүүлэн өөрийн болгосноор үзэсгэлэнт бэрийн бэлтгэлээ дуусгаж, Эзэний ирэлтийг хүлээж байх хэрэгтэй билээ.

Хайрт итгэгч та бүхэн минь,

Бид Бурханы Үгийг хэрхэн даган үйлдсэнээр дамжуулан энэ газар дээрх амьдрал төдийгүй Тэнгэрийн оронд ч мөн байрлах байр суурь ба авах шагнал нь өөр бөгөөд амьдрал маань өөрчлөгддөг билээ. Тиймээс, Бурханы тушаасан үг бүрийг сахин биелүүлж, эцэстээ тэнгэрийн оронд ч сүр жавхлантай байранд орохыг Эзэн Есүс Христийн нэрээр хүсэн ерөөе!

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул,
152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
e-mail: manminministry@hotmail.com
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин

Та Аравны нэгээ төгс зөв өргөж байна уу?

Бурхан бол атгаг нэгэнд соригддоггүй, Өөрөө хэнийг ч сорьдоггүй төгс Эрхэм билээ. Гэтэл Хуучин гэрээний Малахи номын 3:10-д, “Миний өргөөнд хоол хүнс байхын тулд бүхий л аравны нэгээ агуулахад авчир. Би та нарын төлөө тэнгэрийн цонхыг нээж, та нарын төлөө ивээлийг хальтал асгах эсэхийн талаар Намайг одоо үүгээр шалга гэж түмэн цэргийн ЭЗЭН айлдаж байна.” хэмээсэн байдаг. Энэ нь ямар утгатай юм бол?

Аравны нэг гэдэг нь олсон орлогынхоо аравны нэгийг өөрөөр хэлбэл арав хуваасаны нэгийг тусгайлан авч Бурхандаа өргөхийг хэлдэг. Энэ нь Израйлийн ард түмэнд Египетээс гарсаны дараа Бурхан энэхүү хуулийг өгсөн байдаг. Хуучин Гэрээний бүхий л хууль тушаалуудыг өнөөдөр ч гэсэн бүгдийн сахих ёстой биш ч гэсэн одоо бол Шинэ Гэрээний үе гээд Бурханы өгсөн хуулинд агуулагдсан Түүний хүсэл алга болох бус (Матай 5:17) Харин ч бид аравны нэгийн хууль түүнд агуулагдсан Бурханы хүслийг ойлгон улам төгс сахин хэрэгжүүлэх хэрэгтэй билээ.

Хуучин Гэрээний Малахи номын 3:8-9-д, “Хүн Бурханыг луйвардах уу? Гэсэн ч та нар Намайг луйвардаж байна! Гэвч та нар Бид Таныг яаж луйвардсан юм бэ? гэдэг. Аравны нэгээр ба өргөлөөр. Танай үндэстэн бүхэлдээ Намайг луйвардаж байгаа тул та нар хараалаар хараагдсан!” хэмээн айлдсан байдаг. Өөрөөр хэлбэл, энэ нь Бурханд аравны нэгээ өргөхгүй байна гэдэг нь Бурханы зүйлийг хулгайлж Түүнийг луйвардаж буй гэмт үйлдэл хэмээн айлдаж байгаа юм.

Матай номын 23:23-д, Есүсээс “Хоёр нүүрт хуулийн багш нар, фарисайчууд та нар золгүй еэ! Учир нь та нар гаа, гоньд, зирааны аравны нэгийг өгдөг атлаа хуулийн чухал нөхцлүүд болох шударга ёс, өршөөл, итгэлтэй байдлыг орхигдуулдаг. Чухамдаа бусдыг нь ч орхилгүй, эдгээрийг биелүүлэх ёстой байсан.” хэмээн айлдсан байдаг. Энэ нь аравны нэгээ өргөхдөө шударга ёс, өршөөл, итгэлтэй байдал нэг үгээр хэлбэл Бурхандаа өргөхдөө хайраараа чин зүрх сэтгэлээсээ уг аравны нэгийн хуулинд нийцүүлэн өргөх гэсэн үг юм.

Энэ мэт Аравны нэг болон ариун Амралтын өдөр, Эзэний өдрийг ариунаар сахихтай хамт Бурханы хүүхдүүдийн хийх ёстой үүрэг бөгөөд энэ нь Бурханд итгэлийн баталгаа болон Түүн руу хандсан хайрын илэрхийлэл юм. Аравны нэгээ өргөх нь Бүхнийг Бүтээгч Бурхан бидний бүх орлого төдийгүй бүх эд баялагийн эрх мэдлийг эзэмшдэг Эрхэм билээ хэмээн хүлээн зөвшөөрч, итгэдэгийн илэрхийлэл бөгөөд бидний амьдралд хэрэгцээ орлого, эд хөрөнгийг өгсөн Бурхандаа талархан өргөдөг хайрын үйлдэл юм.

◆ Та бүх орлогынхоо аравны нэгийг өргөдөг үү?

Хэрэв таны сарын орлого тань 1 сая төгрөг боловч та татвар, нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, өөр бусад суутгалууд гэсээр гар дээрээ найман зуун мянган төгрөг авдаг байлаа гэж бодъё. Тэгвэл та аравны нэгийн дагуу өргөхийн тулд хэдийг өргөх вэ? Энэ тохиолдолд та төгс аравны нэгийг өргөмөөр байвал дээрх суутгалууд нь таны нийт орлогоос хасагдсан тул нийт орлого нь 1 сая төгрөг хэмээн тооцож арав хуваасаны нэгийг өргөх хэрэгтэй билээ.

Мөн түүнчлэн, хэн нэгэн таныг хоолонд урих, эсвэл та хэн нэгнээс бэлэг авсан зэрэг нэмэлт орлого бүхий энэ тохиолдолд тэдгээр зүйлийг аравны нэгтээ оруулан тооцох хэрэгтэй билээ. Ингэхдээ тухайн үеийн нөхцөл байдал дайллага, бэлэгний үнэ болон бусад орлогын хэмжээг яг цав эргэн санах тооцоолох нь амаргүй, боломжгүй тул эрхэм та аравны нэгээ өргөхдөө эдгээр зүйлийг оролцуулан өөрийн нийт орлогын хэмжээнээс тооцсон аравны нэгээс илүүгээр хангалттай хэмжээгээр өргөх нь хамгийн зөв юм. Ийм тохиолдолд л аравны нэгээ бүрэн төгс өргөж байгаа хэмээн хэлэх боломжтой билээ.

◆ Аравны нэгээ бусад өргөлүүдээс тусад нь өргөдөг үү?

Магадгүй өөрийн нийт орлогоос аравны нэгийг таслан авч өргөдөг гэх боловч тусламж үзүүлэх юм уу сайн мэдээ тараах үйлсэд ашиглаж байна уу гэдгийг анхаарах хэрэгтэй. Зарим хүмүүс бүх орлогоосоо аравны нэгийнхээ хэмжээний мөнгийг таслаж аваад, түүнийг дахин хуваан бусад өргөлүүдийг өргөх юм уу, эсвэл аравны нэгийн зарим хэсгийг тусламжийн үйлсэд зориулна уу гэх тохиолдол ч байдаг.

Гэвч аравны нэг нь бидний бүх орлогоос ‘Бурханд ноогдох хувь’ учраас түүнийг тусад нь таслан авч өргөгдөн, заавал бусад өргөлүүдээс тусдаа өргөгдөх ёстой билээ. Аравны нэгээ өргөх ёстой байтал түүнийг бусад өргөлөөр өргөх юм уу өөр зүйлд ашиглавал та ‘Бурханд ноогдох хувийг’ өөрийн дураараа хэрэглэсэн бөгөөд энэ нь Түүнийг луйвардан мэхэлж байгаа гэсэн үг юм. Тиймд бид Бурхандаа аравны нэгээ зөв өргөхгүй бол Бурханы эд зүйлсийг хулгайлж байна гэдгээ санах хэрэгтэй билээ.

◆ Сүнсний тэжээлийг өгдөг сүмдээ та аравны нэгээ өргөдөг үү?

Хэрэв таны очдог сүм болон сүнслэг тэжээлийг өгдөг сүм чинь өөр бол эрхэм та аль сүмдээ аравны нэгээ өргөх вэ? Маш хүнд өвчтэй хүн эмнэлэгт эмчлүүлээд бие нь сайжирч, эдгэрвэл эмчилгээний төлбөрийг өөрийг нь эмчилж өгсөн эмнэлэгтээ л төлдөг. Үүнтэй адил аравны нэг ч бас мөн адил билээ. Сүнслэг сургаалиар итгэлийн үрийг суулган амьдралыг тэтгэж буй өөрөөр хэлбэл өөрийн сүнс сэтгэлийг тэтгэж өгдөг сүмдээ та аравны нэгээ өргөх хэрэгтэй юм.

◆ Өөрийнхөө нэр дээр та аравны нэгээ өргөдөг үү?

Зарим үед та аравны нэгээ өргөхдөө гэр бүл, эхнэр нөхөр, зэргээр нийтэд өргөдөг үү гэдгээ эргэж нэг хараарай. Бурхан хүн тус бүрийн үйлсээр дамжуулан шагнал өгдөг тул бие даан хүн тус бүрийн нэрээр аравны нэгээ өргөх ёстой юм.

Бурханд итгэдэггүй нөхрөө ерөөл хүртүүлэхийн тулд эхнэр нь нөхрийнхөө нэрээр аравны нэгээ өргөдөг бол Бурхан эхнэрийнх нь чин сэтгэл ба итгэлийг хараад нөхөрт

нь авралын боломжыг өгөх тохиолдол бий. Гэвч, юуны түрүүнд нөхөр нь Эзэнийг хүлээн авах, итгэл суулгах нь маш чухал юм. Мөн түүнчлэн, бид үр хүүхдүүдээ ч аравны нэгийг хэрхэн өргөх тухай зааж өгөх хэрэгтэй билээ.

Эдгээрээс гадна онцгой тохиолдлууд гэж бий. Эцэг эх нь хүүхдүүдээ, эсвэл хүү бэр, охин хүргэндээ өвлүүлэн үлдээх юм уу хамтдаа хөрөнгө оруулан аж ахуй, бизнес эрхлэх тохиолдолд тэр нь дундын эзэмшил учир 2 хүний нэрээр аравны нэг өргөж болно. Эсвэл тэдгээр хүмүүс нь өөрсдөд ноогдох өв хөрөнгөө хуваан аравны нэгээ өргөх үе ч байдаг.

◆ Сард та нэгээс илүү аравны нэгээ өргөдөг үү?

Аравны нэг нь орлого олсон тухай үе бүрдээ өргөх юм уу хамгийн багадаа нэг сар болгон олсон орлого, бэлэг сэлт болон өрхийн орлогоо сард тооцоолон өргөх хэрэгтэй билээ. Газар тариалан эрхэлдэг хүмүүсийн хувьд тэдгээр хүмүүс жилийн орлогоор тооцдог ч бэлэг, тусламж гэх мэт орлого олсон тэр тохиолдол болгондоо аравны нэгээ өргөвөл сайн.

Нөхөр нь эхнэртээ аравны нэгээ өргөсний дараа тодорхой хэмжээний мөнгө өгч байгаа бол эхнэр нь тэр мөнгөнөөсөө аравны нэг өргөх хэрэггүй. Хүүхдүүд эцэг эхээсээ хэрэглээний мөнгө юм уу бэлэг авсан тохиолдолд аравны нэг өргөх хэрэгтэй ч сургалтын төлбөр гэх зүйлст аравны нэг өргөх шаардлагагүй юм. Учир нь тэдгээр мөнгө нь хүүхдийн орлого биш сургалтын бусад зардлыг эцэг эх нь төлж байгаа учраас юм. Мэдээж хэдийгээр нялх хүүхэд ч гэсэн түүний төрсөн өдрийн баяр, түүний өгөгдсөн бэлэг сэлтнийхээ аравны нэгийг хүүхдийнхээ нэрээр өргөх хэрэгтэй билээ.

Хэрэв хүүхэд нь төгөлдөр хуур эсвэл компьютер зэрэг үнэтэй бэлэг авсан тохиолдолд хүүхэд өөрөө түүнийхээ аравны нэгийг өргөхөд хэцүү тул эцэг эх нь хүүхдийнхээ нэрээр өмнөөс аравны нэгийг нь өргөх хэрэгтэй билээ. Гэхдээ үнэтэй бэлэг байлаа гэхэд түүний аравны нэгийн хэмжээ их бөгөөд эцэг эх нь энэ хэмжээний аравны нэгийг өргөх чадалгүй байх тохиолдол болон итгэдэггүй эцэг эх өргөөгүй тохиолдолд Бурхан тэр хүүхдийг аравны нэгээ өргөөгүй хэмээдэггүй билээ.

Хүүхэд сургалтын тэтгэлэг авах үед эцэг эх нь хүүхдийнхээ нэрээр аравны нэгийг нь өргөх юм уу сургалтын төлбөрийг өгч буй эцэг эхийнхээ нэрээр өргөсөн ч болно. Гэр бүлийн байдал боломжгүй сурагчид ийм тэтгэлэгийн мөнгийг бүгдийг нь хичээлдээ ашиглах учир мөнгөтэй болсон үе бүрдээ тооцоолон өргөх юм уу ажилд ороод орлоготой болсон үед өргөх хэрэгтэй.

◆ Та бүх орлогоосоо хамгийн эхэнд аравны нэгээ таслан авч өргөдөг үү?

Тухайн орлого олсон тохиолдол болгондоо аравны нэгээ тусад нь салган авбал та ямар санхүүгийн эрсдэл болон бусад шалтгаанаас болж өргөж чадахгүй байх тохиолдол байхгүй болох бөгөөд хэрэв гэнэтийн чухал хэрэгцээний мөнгө, эсвэл гэр байр гэх мэт томоохон зүйл худалдан авах зорилгоор банкнаас мөнгө зээлдэх эсвэл бизнесийн ямар нэгэн хөрөнгө оруулалт авлаа гэхэд үүнийг ч орлого хэмээн тооцно. Энэ үед итгэлтэй хүн бол зээл авахдаа аравны нэгийн хувиа ч гэсэн тооцон өөрт хэрэгтэй хэмжээнээс аравны нэгээ оролцуулан хангалттай хэмжээгээр зээл авдаг. Хэрэв ингэх боломжгүй тохиолдолд өөрийн хийх гэж буй үйлсээ дахин нэг нягтлан харах нь зүйтэй юм. Ямар ч тохиолдолд аравны нэгээ төгс өргөдөг бол ямар ч үйлс хийхэд зөв алхам болно гэдгийг санах нь зүйтэй бизээ.

Улаанбаатар Манмин Сүм

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:

Г. Анхбаяр СМТ 976-91173712

976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Би Буддын сүмд лам аав бөгөөд Буддист гэр бүлд төрж өссөн билээ. Айлын ууган хүү болж төрсөн боловч одоо би Буддын шашинт Тайланд улсад Христийн сайн мэдээг гэр бүлийнхээ хамт тунхаглан түгээсээр байгаа билээ.

Буддын шашинтай орон болох Тайландад Христийн сайн мэдээг түгээж, ард олон нь энэ сайн мэдээг сонсоод хүлээн авахад олон шахалт дарамт нийгмийн хэмжээний хавчлагатай тулгардаг билээ. Хэдий тийм ч гэсэн, бид Ариун Сүнсний хүч чадлаар амьд оршигч Бурханыг баглан тунхаглаж эрч хүчтэйгээр сайн мэдээг тарааж энэ хэмжээний үр дүнд, үр жимстэй болдог нь зөвхөн Эзэний минь ивээл билээ.

Бараг 20-иод жилийн өмнө, Тайландад сайн мэдээ тарааж байгаад амжилтгүй болж түүнээс хойш энгийн амьдралаар амьдарч байв. Гэтэл Манмин Төв Сүмийг олж мэдсэний дараа миний амьдрал өөрчилөгдөж эхлэв. 1998 онд би Доктор И Жей руг тэргүүн пасторын залбирлаар би архаг нурууны диск, өвчнөөсөө, миний эхнэр хүүхэд төрүүлсэний дараах үрэвсэлт өвчнөөсөө эдгэрсэн юм.

Мөн түүнчлэн Доктор И Жей руг тэргүүн пастор библийн ойлгоход хэцүү ишлэлүүдийн утгыг тайлж өгөн тэнгэрийн орны талаар гүн гүнзгий ойлголт болон хүсэл тэмүүлэлийг өгч, үүнтэй хамт дагалдах тэмдэг гайхамшигууд ба Бурханы амьд оршин буйг баталж буй итгэлийн амьдрал үнэхээр аз жаргалтай байлаа. Тэр аз жаргал ба сэтгэл хөдлөл намайг дахин Тайландад сайн мэдээ тараах хүсэл ба урам зоригыг маань дүрэлзүүлсэн юм.



“Гэр бүлээрээ сайн тараахад үнэхээр аз жаргалтай байна”

И Жаевон Сайн мэдээ тунхаглагч (Тайланд Чиан Рай Манмин Сүм)

2009 оны Арваннэгдүгээр сард, Тайланд руу олон хүмүүс Манмин төв сүм болон Доктор И Жей руг тэргүүн пасторын тухай GCN ТВ-ээр илгээгдсэн юм. Тухайн үед Тайландын маш

мэдэг болсон байв. Мөн түүнчлэн, Доктор И Жей руг тэргүүн пасторын арваад номууд хэвлэгдэн гарсан байсан тул номлолын ажил хийхэд амар хялбар байв. Би цаг л байвал олон сүмүүд дээр очин ‘Бурханы хүч чадал’ хэмээх DVD-г үзүүлэн залбирал хийж өгдөг байлаа. Мөн ‘Манмин Мэдээ’ сонинг ойролцоогоор Тайландын 2500-аад сүмүүдэд тараан түгээдэг байв. Үүний үр дүнд маш олон номлогч нартай холбоо тогтоосон юм.

2011 оны Тавдугаар сард Манмин төв сүмийн номлолын багынхантай хамт бид Тайландын Хүүхдийн хорих төвд урлагын тоглолт болон Ивээлийн цуглааны үйл ажиллагаа явуулав. Энэ үйл ажиллагаа нь олны хүндэтгэл ба талархалыг маш их хүлээн авсан тул Хааны нэрэмжит цэргийн академид болон өөр нэгэн Хүүхдийн хорих газар 2012 оны Гуравдугаар сард дахин тоглосон юм. Тэр үеэр бид төрийн өндөр албан тушаалын хүмүүстэй уулзан, сайн мэдээний талаар танилцуулах номлох боломж олдсон ба Солонгосын урлагын багынханы тоглолт болон ‘Бурханы хүч чадал’ хэмээх DVD-г үзүүлж сонирхуулав.

Одоогын байдлаар, Тайландад Манмин төв сүмтэй холбоотой 130-аад хамтарсан сүм байгаа билээ. Тайланд нь Вьетнам, Лаос, Кампуч болон Балбын орнуудтай хил залган оршдог тул сайн мэдээ тараахад маш тус дөхөмтэй газар билээ. Ирэх жилийн 2-р хагаст Вьетнам, Кампуч, Лаос ба Балбын орнуудад Номлогчдын семинарыг зохион байгуулах талаар бэлдэж байгаа билээ. Бүхий л талархал ба алдрыг Гуравын холбооны Бурхандаа өргөн барья.

“Тайланд залуучуудыг сэргээхийг хүсэж байна”

И Жейвон номлогчын ууган хүү И Син хүн (19 настай)



Би бага байхдаа Ондервоод ба Сонда шин нар шиг алдарт номлогч нарын тухай 20иод номыг дахин дахин уншиж өссөн болохоор эцэг эхтэйгээ хамт баяртай сэтгэлээр Тайланд руу явсан юм. Тайландад очоод

гурван сар болсоны дараа бид сүмээ нээсэн боловч хөгжмийн зэмсэг болон хөгжимчид байхгүй байв. Тиймээс би хөгжим тоглож сурахын тулд гитар хөгжим сурч эхэлсэн ба Эзэний ивээлээр бага багаар тоглодог болж одоо бейс гитар хүртэл тоглодог болсон юм.

Чиан Рай Манмин сүмд Солонгос хэлний хичээл зааж, оюутануудад сайн мэдээ тарааж байгаа билээ. Би ээж, И Сүн уг номлогчид туслан хажуугаар нь оюутануудад Солонгос хэл зааж байна. Эдгээр хүмүүс сайн мэдээг дуртайяа хүлээн авч, эцэстээ сүмийн ажилчин болж байгаа юм. Цаашдаа Тайландын залуучуудыг Солонгосын урлаг хэл соёлыг судлах хүсэл сонирхолыг дагуулан би ч гэсэн үүнийг заамагцаа энэ залуусыг сэргээхийг хүсч байгаа билээ.

“Би бүх хүчээрээ хичээхэд Бурхан надад тусалсан юм”

Хоёр дохь хүү И Сон хёон (16 настай)



Багаасаа би сайн мэдээний ажил хийхийг хүсдэг байсан тул би Тайландад баяр хөөртэйгээр явж очив.

Одоо би Чиан Рай Манмин сүмд би цахилгаан даралтат хөгжим тоглодог юм. Эхлээд, би долоо хоногт нэг цагаар хоёр сарын турш даралтат хөгжим заалгадаг байсан

ба үүний дараа би сурах зав чөлөөгүй болж эцэстээ заалгаж чадахгүй болов. Нэг өдрийн өмнө ч гэсэн би өөрөө оролдон сурч байсан ба аль болох хурдан сураад Бурханд үйлчилэх хүсэлтэй байсан боловч энэ нь тийм ч амаргүй байв. Нойр ихтэй миний хувьд өглөө эрт босох маш хэцүү байсан боловч үүрээр босон дасгал хийж эхлэн үд хүртэл хийгээд мөн хичээлийн дараа чөлөөт цагаараа сургуулилан хичээллэдэг байв. Мөн хурдан сурч тулд би мацаг барин Бурханд залбирдаг байлаа. Үүний үр дүнд би гурван сарын дотор магтаал дуунуудыг тоглож чаддаг болов.

Ийм миний байдлыг харсан сүмийн итгэгчид сэтгэл нь хөдлөж, зарим итгэгч энэ хугацаанд ингэж хичээн зүтгэж чадаагүйдээ гэмшиж байлаа. Миний ийм өчүүхэн зүтгэл маань манай сүмийн итгэгчдийг өөрчлөн зүрх сэтгэлийг хөдөлгөсөнд гайхан Бурхандаа талархлаа өргөсөн билээ.

“Энийг ч тэрийг ч гээд л туслах ажил их тул аз жаргалтай байна”

Отгон хүү И Сон гёол (14 настай)



Хэдийгээр нас минь бага ч гэсэн би Тайландад хийх ажил маш их байгаа билээ. Эзэний өдрийн хүүхдийн цуглааны багш, сүмийн гал тогоонд туслагчаар ажиллаж, сүм чимэглэх цэвэрлэх,

сайн мэдээ тараах зэрэг ажлуудыг хийгээд их завгүй байдаг. Мөн би өөрөө оролдож байгаад бөмбөр тоглож сурсан ба урлагын багынханы тоглолтонд хамтран оролцдог. Заримдаа би ээждээ солонгос хэл заахад нь тусладаг билээ. Энэ мэт өдөр тутам бүх хүчээ дайчлан хичээллэхэд нэг л мэдэхэд Тайланд хэл ба Англи хэлний түвшин ч сайжирсан байсан юм.

Хоёр сарын өмнө миний хөл дээр 20 гаруй тооны үү мэт цэврүү гарч өвдөж байсан боловч эрх мэдэлт хүчит ‘Мүан амтат ус’-г хөл дээрээ түрхсэний дараа нэг өдрийн дараа цэвэрхэн эдгэрсэн юм. Бурханы хаанчлалын төлөө хэдийгээр өчүүхэн зүйл хийж байгаа миний дүр төрхийг Бурхан баярлаж байна хэмээн би хувьдаа боддог юм.

Монгол Манмин Төв Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
www.manmintv.org